БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албаны** 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2020/121/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он


Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: З.Ганбаатар

Утас: 99411126 Цахим хаяг Ganbaatarz@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ...... 3
Аудитын тайлан ...... 5
2.1. Оршил ...... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ...... 5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ...... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ...... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ...... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ...... 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ...... 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ...... 7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...... 7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ...... 8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...... 8
2.13. Шилэн дансны мэдээлэл ...... 8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ...... 9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ...... 9
Менежментийн захидал ...... 10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ...... 11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ...... 11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...... 12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ...... 13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...... 15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ...... 15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ...... 18

## Аудитын гэрчилгээ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.14 № 41

танай ______________-ны №________________т

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГА П.ЦОГБАДРАХ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох

006020077

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

**2.1. Оршил**

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Газрын дарга П.Цогбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

**2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 08–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 13/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн" гэж заасны дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 27 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 69783.9 мянган төгрөгөөс тооцон 1395.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардал болох 151413.6 мянган төгрөгөөс 2 хувь болох 3028.3 мянган төгрөгийг материаллаг байдлаар тогтоох нь зүйтэй гэж үзлээ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7748.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | 15912 | 15912 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 1351420 | 1351420 | 1351420 |
| Үндсэн хөрөнгө | 47462167.93 | 39697812.92 | 7764355.02 |
| **Нийт хөрөнгө** | 48813587.93 | 41065144.91 | 7748443.02 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 48813587.93 | 41065144.91 | 7748443.02 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 48813587.93 | 41065144.91 | 7748443.02 |

Авлага дансны үлдэгдэл өссөн нь татварыг илүү бодож шилжүүлснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн, 15.9 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд өссөн, буурсан үзүүлэлтгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны элэгдлийн зардлын дүнгээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл тайлант онд үүсээгүй байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган аймгийн Шүүх шинжилгээний алба нь тайлант онд 4000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4673.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 673.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Шинжилгээний орлого | 4000.0 | 4673.0 | 673.0 | 116.8 |
| **Нийт дүн** | **4000.0** | **4673.0** | **673.0** | **116.8** |

Булган аймгийн Шүүх шинжилгээний албаны орлого 673.0 мянган төгрөгөөр давсан нь шинжилгээний орлогыг 2018 оны 07 дугаар сарын 01-нээс үзлэг шинжилгээний үйлчилгээний тарифт өөрчлөлт орсон /3 сайдын тушаал/-аас шалтгаалж байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан төсвөөс 137867.2, өөрийн орлогоос 4000.0 нийт 141867.2 мянган төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 4673.2, төсвөөс 137867.2 мянган төгрөгийн санхүүжилт авчээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвөөс 141695.8 мянган төгрөгийг зарцуулж, урсгал зардлаас 171.4, давсан орлогын 673.2 нийт 844.6 мянган төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл 99.8 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болох 1124.8 мянган төгрөг нь өмнөх оны үлдэгдлийг олгосон санхүүжилтийг бичиг хэрэгт 262.0, түлш халаалт 144.5, дотоод албан томилолт 541.6, бага үнэтэй, түргэн элэгдэх эд ахуйн зүйлст 176.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шат, гүйцэтгэх үе шатанд нийт 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1124.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1124.8 мянган төгрөгийн алдааг залруулж ажиллаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараа онд шинжилгээний орлогыг 2018 оны 07 дугаар сарын 01-нээс үзлэг шинжилгээний үйлчилгээний тарифт өөрчлөлт орсонтой холбоотойгоор орлогын төлөвлөгөө болон биелэлтийг бодит төлөвлөж байгаа эсэхийг анхаарах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 117 мэдээллийг хугацаанд нь 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь өмнөх аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмжийн бүртгэлд байхгүй болно.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган аймгийн Шүүхийн шинжилгээний албны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй эрсдэлгүй гэж үзсэн тул тайлант оны санхүүгийн аудитын тайланд зөвлөмж хүргүүлээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,351,420.00** | **1,367,332.00** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 15,912.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 15,912.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 15,912.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,351,420.00 | 1,351,420.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 723,520.00 | 723,520.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 573,000.00 | 573,000.00 |
| 35130 | Эм боох материал | 150,520.00 | 150,520.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 627,900.00 | 627,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 143,400.00 | 143,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 484,500.00 | 484,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,462,167.93** | **39,697,812.91** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 47,462,167.93 | 39,697,812.91 |
| **392** | **Биет хөрөнгө** | 40,212,167.93 | 32,447,812.91 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,200,000.00 | -3,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,484,570.40 | 41,277,550.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -34,577,342.48 | -26,255,469.94 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,484,510.00 | 9,591,310.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,979,569.99 | -7,165,577.15 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **48,813,587.93** | **41,065,144.91** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **48,813,587.93** | **41,065,144.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 48,813,587.93 | 41,065,144.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,902,720.00 | 10,902,720.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 10,902,720.00 | 10,902,720.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 37,910,867.93 | 30,162,424.91 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 37,910,867.93 | 37,910,867.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7,748,443.02 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 00.00 | 00.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 00.00 | 00.00 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 00.00 | 00.00 |
| 51600 | Нөөцийн сан | 00.00 | 00.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **48,813,587.93** | **41,065,144.91** |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **171,542,300.00** | **143,665,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **49,045,300.00** | **5,798,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 49,045,300.00 | 5,798,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 49,045,300.00 | 5,798,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,149,500.00 | 5,798,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 42,895,800.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **122,497,000.00** | **137,867,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 122,497,000.00 | 137,867,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 122,497,000.00 | 137,867,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **141,330,637.07** | **151,413,643.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **141,330,637.07** | **151,413,643.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 138,763,277.95 | 150,569,083.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98,285,350.00 | 112,966,194.00 |
| 210101 | Үндсэн цалин | 58,142,350.00 | 60,308,844.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,950,000.00 | 42,481,350.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,193,000.00 | 10,176,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,317,601.20 | 2,572,139.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 975,333.31 | 780,095.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,342,267.89 | 1,792,043.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,881,349.00 | 6,683,676.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 626,088.00 | 390,457.07 |
| 210302 | Түлш, халаалт | 4,866,841.00 | 4,866,850.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,388,420.00 | 1,426,369.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,037,144.68 | 9,617,569.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,610,920.00 | 1,262,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,499,821.00 | 5,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,469,849.68 | 1,321,219.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 32,000.00 | 27,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,424,554.00 | 1,207,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,861,150.00 | 4,381,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,383,350.00 | 2,541,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,022,800.00 | 1,839,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,455,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,174,340.00 | 600,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,219,990.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 954,350.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,491,100.00 | 5,041,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,491,100.00 | 5,041,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,186,540.00 | 942,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,186,540.00 | 799,310.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 65,340.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 37,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилогоо | 00.00 | 30,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 10,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,528,703.07 | 7,764,355.02 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,528,703.07 | 7,764,355.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,567,359.12 | 844,559.10 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,567,359.12 | 844,559.10 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,567,359.12 | 844,559.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **30,211,662.93** | **-7,748,443.02** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **30,211,662.93** | **-7,748,443.02** |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **128,646,500.00** | **143,665,200.00** |
| 118304 | Нохойны албан татвар | 00.00 | 00.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,149,500.00** | **5,798,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,149,500.00 | 5,798,000.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 00.00 | 00.00 |
| 120002 | Хүүгийн орлого | 00.00 | 00.00 |
| 120003 | Торгуулийн орлого | 00.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,149,500.00 | 5,798,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,149,500.00 | 5,798,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **122,497,000.00** | **137,867,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 122,497,000.00 | 137,867,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 122,497,000.00 | 137,867,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **128,646,500.00** | **143,665,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **128,646,500.00** | **143,665,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **126,079,140.88** | **142,820,640.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98,285,350.00 | 112,974,150.00 |
| 210101 | Үндсэн цалин | 58,142,350.00 | 60,316,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 28,950,000.00 | 42,481,350.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,193,000.00 | 10,176,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,317,601.20 | 2,580,095.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 975,333.31 | 780,095.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,342,267.89 | 1,799,999.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,881,349.00 | 6,683,676.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 626,088.00 | 390,457.07 |
| 210302 | Түлш, халаалт | 4,866,841.00 | 4,866,850.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,388,420.00 | 1,426,369.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,799,790.68 | 9,617,569.74 |
| 210401 | Бичиг хэрэг | 998,120.00 | 1,262,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,499,821.00 | 5,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,469,849.68 | 1,321,219.74 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 32,000.00 | 27,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 1,207,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,517,570.00 | 4,381,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,494,770.00 | 2,541,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,022,800.00 | 1,839,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,599,840.00 | 600,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 569,990.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,029,850.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,491,100.00 | 5,041,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,491,100.00 | 5,041,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,186,540.00 | 942,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,186,540.00 | 799,310.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 65,340.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 37,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 30,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 10,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,567,359.12** | **844,559.10** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,567,359.12 | 844,559.10 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,567,359.12 | 844,559.10 |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,652,720.00 | 12,100,082.85 | 15,752,802.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 3,652,720.00 | 12,100,082.85 | 15,752,802.85 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 479,819.00 | 479,819.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 10,902,720.00 | 37,910,867.93 | 48,813,587.93 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 10,902,720.00 | 37,910,867.93 | 48,813,587.93 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 10,902,720.00 | 37,910,867.93 | 48,813,587.93 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7,748,443.02 | -7,748,443.02 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 10,902,720.00 | 30,162,424.91 | 41,065,144.91 |

## 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 127,997,000.0 | 126,079,140.88 | 141,867,200 | 141,695,840.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 127,997,000.0 | 126,079,140.88 | 141,867,200 | 141,695,840.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 127,997,000.0 | 126,079,140.88 | 141,867,200. | 141,695,840.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 98,285,800.00 | 98,285,350.00 | 112,980,000 | 112,974,150.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 58,142,800.00 | 58,142,350.00 | 60,316,800 | 60,316,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 28,950,000.00 | 28,950,000.00 | 42,487,200 | 42,481,350.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,193,000.00 | 11,193,000.00 | 10,176,000 | 10,176,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 2,587,200.00 | 2,580,095.09 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,757,200.00 | 975,333.31 | 787,200.00 | 780,095.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 172,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 215,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 43,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,800,000.00 | 1,342,267.89 | 1,800,000.00 | 1,799,999.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,030,000.00 | 6,881,349.00 | 6,641,700.00 | 6,539,226.07 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 630,000.00 | 626,088.00 | 454,900.00 | 390,457.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,900,000.00 | 4,866,841.00 | 4,722,400.00 | 4,722,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,500,000.00 | 1,388,420.00 | 1,464,400.00 | 1,426,369.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210304 | Байрны түрээс | 7,870,000.00 | 7,799,790.68 | 9,186,500.00 | 9,178,819.74 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,000,000.00 | 998,120.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,500,000.00 | 4,499,821.00 | 5,800,000.00 | 5,800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,470,000.00 | 1,469,849.68 | 1,326,000.00 | 1,321,219.74 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 32,000.00 | 29,900.00 | 27,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, | 800,000.00 | 800,000.00 | 1,030,600.00 | 1,030,600.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,524,000.00 | 3,517,570.00 | 4,381,100.00 | 4,381,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,500,000.00 | 2,494,770.00 | 2,541,900.00 | 2,541,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,024,000.00 | 1,022,800.00 | 1,839,200.00 | 1,839,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,600,000.00 | 1,599,840.00 | 600,000.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 600,000.00 | 569,990.00 | 600,000.00 | 600,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | 1,029,850.00 | 00.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 4,491,100.00 | 4,500,000.00 | 4,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 4,500,000.00 | 4,491,100.00 | 4,500,000.00 | 4,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,200,000.00 | 1,186,540.00 | 990,700.00 | 942,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,200,000.00 | 1,186,540.00 | 800,000.00 | 799,310.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 | 100,000.00 | 65,340.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 | 50,000.00 | 37,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 00.00 | 30,000.00 | 30,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 10,700.00 | 10,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 127,997,000.0 | 126,079,140.88 | 141,067,200. | 142,540,400.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 122,497,000.0 | 119,929,640.88 | 137,067,200 | 137,867,200.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 122,497,000.0 | 119,929,640.88 | 137,067,200 | 137,867,200.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,500,000.00 | 6,149,500.00 | 4,000,000.00 | 4,673,200.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,500,000.00 | 6,149,500.00 | 4,000,000.00 | 4,673,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,020.00 | 58,301.00 | 1,020.00 | 58,301.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 555.00 | 7,878.00 | 555.00 | 7,878.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 455.00 | 4,545.00 | 455.00 | 4,545.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 45,878.00 | 10.00 | 45,878.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 127,997,000.0 | 126,079,140.88 | 141,867,200. | 141,695,840.9 |

## 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| Бичиг хэрэг | 262000 | 262000 |
| Түлш халаалт | 144450 | 144450 |
| Дотоод албан томилолт | 541600 | 541600 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх эд ахуйн зүйлс | 176750 | 176750 |
| Нийт дүн | 1124800 | 1124800 |